



## ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

### НЭГ.ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү баримт бичгээр “Си И Си Инвестмент ББСБ” ХХК /цаашид “компани” гэх/-ийн эрх бүхий албан тушаалтны нэр дэвшүүлэх, томилох, дуусгавар болгох, залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 1.2 Энэхүү бодлогын зорилго нь компаний эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, компаний үйл ажиллагааг тасаралтгүй, хэвийн явуулах, эрх бүхий тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.3 Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд Компаний тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компаний засаглалын кодекс, бусад хологдох хууль тогтоомж болон энэ бодлогыг баримтлана.

### ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид “Хороо” гэх/ нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж, батална.
- 2.1 Хороо нь компаний ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн болон эрх бүхий албан тушаалтанд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
- 2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтанд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үнэлэх дүгнэх замаар нэр дэвшүүлэх, залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4 Хороо нь компаний эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Мөн компаний хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалтанд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж санал болгоно.
- 2.5 Компаний хүний нөөц хариуцсан нэгж нь Хороонд судалгаа, тайлан хүргүүлэх, хамтарсан төлөвлөгөө гаргах замаар хамтарч ажиллана.
- 2.6 Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүд болон эрх бүхий албан тушаалтан, компаний ажилтнуудын хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино.
- 2.7 Хороо нь компаний цаашдын өсөлттэй холбогдуулан нэр дэвшигч бэлэн байгаа эсэх, хүний нөөцийн эрсдэл тулгарч буй эсэхт үнэлэлт, дүгнэлт өгнө. Мөн эрх бүхий албан тушаалтнаас тухайн жилд ажлаас чөлөөлөгдөх, шилжих хүсэлтэй байгаа эсэхт судалгаа хийж, хяналт тавина.
- 2.8 ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн эсвэл эрх бүхий албан тушаалтан ажлаас гарах, нас барах, өөр бусад гэнэтийн шалтгаан /урт хугацааны өвчтэй, чөлөөтэй байх үеэс бусад/-ы улмаас орон тоо нь чөлөөлөгдөх тохиолдолд Хороо хуралдаж, орлох этгээдийг тодорхойлон, ТУЗ-д танилцуулж шийдвэрлэнэ.
- 2.9 Өндөр насны тэтгэвэрт гарах, жирэмсний амралт авах гэх мэт таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон компаний хүний нөөц хариуцсан нэгж нь жил бүр судалгаа хийнэ.

“Си И Си Инвесмент ББСБ” ХХК



ГУРАВ.ХЯНАЛТ

- 3.1 Энэ бодлогын хэрэгжилтэнд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

2023 он